



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

### Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянзүрх дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах үүрэг бүхий Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг зөвлөл /Т.Баясах/-д үүрэг болгосугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/201 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА